



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/432

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулж, дэмжлэг үзүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "г", Төсвийн тухай хуулийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны ээлжит бус 10 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цусны хорт хавдар өвчнөөр өвдөж хагалгаанд 2 удаа, хими эмчилгээнд 4 удаа орж байгаа Мөрөн сумын иргэн Мөнхжаргалын Анарт 500,000 төгрөг, байнгын асаргаанд байдаг epilepsi оноштой Нямхүрэлийн Аз-Эрдэнэд 250,000 төгрөгийн дэмжлэг, "Эх хүүхэд нөхөн үржихүйн хөтөлбөр"-ийн хүрээнд эрэгтэйчүүдийн эмчийг бэлтгэсэн сургалтын төлбөрт 416,000 төгрөгийг тус тус олгосугай.

2. Дээрх 1,166,000 (Нэг сая нэг зуун жаран зургаан мянган) төгрөгийг "Эрүүл иргэн-Эрхэм баялаг" дэд хөтөлбөрийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Сувд), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Азаяа) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД